



Баталсан хууль нь хүн
бүрт тэгш үйлчилдэг
төр л халгийн
тогтвортой оршдог.

Аристотель

Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn

Хууль зүйн мэдээ сонин

2024.02.29

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

УИХ-аас 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ХЗҮХ-ийн эрх зүйн үндсийг хуульчлан тогтоосон. Тус хуульд заасны дагуу ХЗҮХ-ээс эрүү,

иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын суурь хууль тогтоомжийн хэрэгжилтэд тогтмол үнэлгээ хийж эхэлсэн. Энэ хүрээнд ХЗҮХ-ээс “Прокурорын хараат бус байдал” болон “Прокурорын

тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгааны тайлангийн хэлэлцүүлгийг 2024.02.06-ны өдөр Хуульчдын танхимд амжилттай зохион байгуулаа.

Үргэлжлэл 2-р нүүрт



Хууль зүйн мэдээ

Улсын бүртгэлийн дугаар 1197

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Эко Интернэйшнл трейд тауэр барилгын 9 давхар,
Хууль зүйн үндэсний хүрээлэн.

11-315789

www.nli.gov.mn

Бэлтгэсэн: Ц.Энхжин

...Үргэлжлэл

ХЗҮХ-ийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах (Dr. jur.) хэлэлцүүлгийг нээн үг хэлэв.



ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х.Буянбат (LL.M) “Прокурорын хараат бус байдал: Прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага” сэдэвт харьцуулсан судалгаа, тус хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан О.Энххүслэн (LL.M) “Прокурорын тухай хуулийн

хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлээ.

Хэлэлцүүлэгт ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтнууд, УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, МУИС-ийн ХЗС, ДХИС, “Хөгжлийн эрх зүйн төв” ТББ, “Ирээдүйн босго” ТББ, “Монголын эрэгтэйчүүдийн холбоо”-ны төлөөлөл, хуульч, судлаачид болон өмгөөлөгчид оролцож санал, зөвлөмж өгөв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь хууль тогтоомжийн хэрэгцээ,

шаардлагыг урьдчилан тандан судлах, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, эрдэм шинжилгээний зөвлөмж, аргачлал боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд шинжлэх ухааны санал дүгнэлт өгөх үндсэн зорилгынхоо хүрээнд 2024 оноос эхлэн мэргэжлийн байгууллага, салбарын төлөөллийг оролцуулан судалгааны тайлангийн хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН АНХНЫ ДАРГА, ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР ГАЛДАНГИЙН СОВДЫН НЭРЭМЖИТ ХУУЛЬ ЗҮЙН СЭДЭВТ ШИЛДЭГ ӨГҮҮЛЛИЙН ШАЛГАРУУЛАЛТ БОЛЛОО

Үндсэн хуулийн Цэцийн анхны дарга, гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Галдангийн Совдын нэрэмжит хууль зүйн сэдэвт шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааныг Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн Судалгааны төв, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран амжилттай зохион байгууллаа.

Уралдааны шалгаруулалтыг доктор, эрдэмтдийн баг явуулж, нийт 11 өгүүлэл ирснээс нэгдсэн дүнгээр Э.Баасандэмбэрэлийн “Эрүүгийн хуулийн нэр томьёо, ухагдахууныг олон улсын гэрээгээр тайлбарлахтай холбоотой зарим асуудал” сэдэвт өгүүлэл 2023 оны хууль зүйн сэдэвт шилдэг өгүүллээр шалгарлаа. Мөн

түүнчлэн 2-р байрыг Г.Сурахбаяр, Ч.Болормаа нарын “Олон нийтийн оролцоо буюу Нийтийн лиценз (Social license to operate Mining): Монгол Улсын Эрдэс баялгийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болох нь” өгүүлэл, 3-р байрыг С.Номынбаясгалан, Э.Тамир нарын “Сонгуулийн эрх зүйн антропологи гэж юу вэ?” гэх сэдэвт өгүүллүүд тус тус эзлэв.

Үндсэн хуулийн Цэцийн анхны дарга, гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Галдангийн Совдын нэрэмжит хууль зүйн сэдэвт шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааныг Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн Судалгааны төв, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран

амжилттай зохион байгууллаа.

Уралдааны шалгаруулалтыг доктор, эрдэмтдийн баг явуулж, нийт 11 өгүүлэл ирснээс нэгдсэн дүнгээр Э.Баасандэмбэрэлийн “Эрүүгийн хуулийн нэр томьёо, ухагдахууныг олон улсын гэрээгээр тайлбарлахтай холбоотой зарим асуудал” сэдэвт өгүүлэл 2023 оны хууль зүйн сэдэвт шилдэг өгүүллээр шалгарлаа. Мөн түүнчлэн 2-р байрыг Г.Сурахбаяр, Ч.Болормаа нарын “Олон нийтийн оролцоо буюу Нийтийн лиценз (Social license to operate Mining): Монгол Улсын Эрдэс баялгийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болох нь” өгүүлэл, 3-р байрыг С.Номынбаясгалан, Э.Тамир нарын “Сонгуулийн эрх зүйн антропологи гэж юу вэ?” гэх сэдэвт өгүүллүүд тус тус эзлэв.



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, АРДЫН БАГШ, ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР, ПРОФЕССОР Б.ЧИМИДИЙН НЭРЭМЖИТ ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙГ 15 ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит шатрын тэмцээнийг 15 дахь жилдээ 2024 оны 02 дугаар сарын 03-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Тэмцээний нээлтэд УИХ-ын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, “Чимид сан”-гийн тэргүүн Ч.Сайнсанаа, Монголын Хуульчдын холбоог төлөөлж Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийн дэмжих хорооны дарга Ц.Мөнхбат, “Цогц-Эрх партнерс” ХХН-ийн удирдах

зөвлөлийн гишүүн Ж.Энхнасан, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Нотариатчдын танхимын ерөнхийлөгч Ч.Баянжаргал, Монголын шатрын холбооны тэргүүн, дэд ерөнхийлөгч Ч.Чулуунбаатар нар оролцов.

Тус тэмцээнд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй дотоод хэргийн яам, Улсын Их хурлын тамгын газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Улсын дээд шүүх, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Монголын Хуульчдын

холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын танхим, Төрийн тусгай хамгаалалтын газрын нийт 52 тамирчин өрсөлдсөнөөс фиде мастер, спортын мастер, дэд мастер цолтой 10 гаруй хүн, Монголын шатрын холбооны рейтингтэй 25 гаруй хүн оролцсон нь энэхүү тэмцээний чансаа өндөр болсныг харуулж байна. Нийт найман өрөг тоглож, тэргүүн байрт спортын мастер Д.Гандуулга, хоёрдугаар байрт фиде мастер Г.Алтан-Оч, гуравдугаар байрт спортын мастер Ч.Чулуунбаатар, тусгай байрт спортын мастер Ц.Мөнхбат, Б.Чинбаатар, спортын мастер Д.Ламжав нар шалгарчээ. Тэргүүн байрын шагналт Д.Гандуулгад Б.Чимидийн нэрэмжит шатрын тэмцээний цомыг гардууллаа.





ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ



Хууль зүйн
үндэсний хүрээлэн

Хүний эрх хамгаалагч гэж хэн бэ?

Ганцаараа болон бусадтай
хамтран үндэсний, бүс
нутгийн олон улсын
эрхийг хамгаалж,
хөхиүлэн дэмжиж байгаа
хүнийг хэлнэ



Төрийн байгууллага, албан тушаалтан хуулийн
этгээд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд
дараах үүрэг хүлээнэ

- ☒ Хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх,
зөрчихгүй байх;
- ☒ Үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах;
- ☒ Хүчирхийллийн бус, тайван аргаар үйл ажиллагаа
явуулах боломж бүрдүүлэх;
- ☒ Шаардлагатай мэдээллээр хангах;
- ☒ Хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа
хэлбэрээр халдахгүй байх;
- ☒ Хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах
зохицуулалтыг байгууллагын дотоод журамд
тусгаж, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах.

Хүний эрх хамгаалагчид хориглох зүйл:

- ☒ Хүчирхийллийн арга хэрэглэж, тайван
бус аргаар үйл ажиллагаа явуулах,
явуулахыг уриалах;
- ☒ Хүний эрх хамгаалагчийн үйл
ажиллагааг хувийн ашиг сонирхолд
ашиглах;
- ☒ Хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр,
алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг
гутаах.



1800-1202

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг энгийн
утасны тарифаар

ТАНЫ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГТ

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГЭЖ ЮУ ВЭ?



✓ **ГОМДОЛ** гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг хэлнэ.


✓ **ӨРГӨДӨЛ** гэдэг нь гомдлоос бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан санал, мэдэгдлийн шинжтэй хүсэлт юм.

✓ Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр болон амаар гаргана. Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно.

✓ Иргэд радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр болон тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргаж болно.



ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ



ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ДАРААХ ТОХИОЛДОЛД ХЯНАН ҮЗЭХГҮЙ, БУЦААНА:

- 1 Өргөдөл, гомдол нь тодорхой **нэр хаяггүй**;
- 2 Бага насны хүмүүс буюу шүүхийн шийдвэрээр эрхийн бүрэн чадамжгүйд тооцогдсон этгээд **эцэг, эх, асран хамгаалагчаараа төлөөлүүлээгүй** бол;
- 3 Төрийн тухайн байгууллага, албан тушаалтанд иргэн өмнө нь хандаж байсан асуудлаар өргөдөл, гомдол гаргасан бөгөөд түүнийг **дахин хянаж шийдвэрлэх үндэслэлгүй**;
- 4 Өргөдөл, гомдолд дурдсан асуудлаар **шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр** байгаа.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАГЧ ДАРААХ ЭРХ ЭДЭЛНЭ:

- Гаргасан өргөдөл, гомдлынхоо **хариуг авах**;
- Өргөдөл, гомдолтойгоо **холбогдуулж тайлбар, нотлох баримт гаргах**;
- Өргөдөл, гомдлоосоо **татгалзаж буцаан авах**;
- Өгсөн хариуг зөвшөөрөөгүй тохиолдолд **зохих дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах**;
- Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, **гомдлоо шийдвэрлүүлэх**.

1800-1202



ЦАГИЙН ХУВААРЬ

08:30-17:30

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН
ЛАВЛАХ ДУГААРТ **08:30-17:30** ЦАГИЙН
ХОРОНД ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР
ХОЛБОГДОХ БОЛОМЖТОЙ

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хорих ялын дээд хэмжээнд өөрчлөлт орсон уу?

Тиймээ. Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг зургаан сараас хорин таван жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ ЦУВРАЛ 115

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

Ямар төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг зогсоож байгаа вэ?

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчиндэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь 18 насанд хүрээгүй бол хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, хохирогчийг 18 насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ ЦУВРАЛ 116

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

Авлига албан тушаалтай холбоотой гэмт хэрэгт өөрчлөлт орсон уу?

Улс төрд нөлөө бүхий этгээд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих зэрэг гэмт хэрэг үйлдсэн бол хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахгүй байх зохицуулалт нэмэгдсэн.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ ЦУВРАЛ 117

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

Бүх насаараа хорих ялаар шийтгүүлсэн хүн суллагдах боломжтой юу?

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар “Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн гучин жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ”.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ ЦУВРАЛ 118

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

08:30-17:30
ЦАГИЙН ХУВААРЬ

ИРГЭН ТА ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ

1800-1202

ДУГААРТ ХОЛБОГДОРОЙ

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

СЕКТОРЫН ЭРХЛЭГЧ

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Ажлын байранд тавигдах ерөнхий шалгуур:

- Хуульч мэргэжилтэй;
- Хууль зүйн ухааны докторын зэрэгтэй;
- Хувийн болон нийтийн эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэшсэн;
- Хууль зүйн судалгааны чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- 1 гадаад хэлний ахисан түвшний мэдлэгтэй.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Дипломын хуулбар;
- Бүтээлийн жагсаалт;
- Төрийн албан хаагчийн анкет;
- 3х4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Хувь хүний намтар;
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.

Гүйцэтгэх үүрэг:

Хууль зүйн сургалт, судалгааны төвийн секторын үйл ажиллагааг удирдах, хууль зүйн болон нийгмийн ухааны тодорхой салбараар ахисан түвшний хавсарга болон суурь судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах, судлаачдыг мэргэжил-арга зүйн зөвлөгөөгөөр хангах.

Бүртгэл: Сонирхсон этгээд бүрдүүлсэн материалаа info@legalinstitute.mn цахим хаягаар ирүүлнэ үү.
Утас: 11-315735

nli.gov.mn

ГРАФИК ДИЗАЙНЕР

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Ажлын байранд тавигдах шаардлага:

- Боловсрол: Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Мэргэжил: График дизайнер
- Ур чадвар: Багаар ажиллах чадвартай, хариуцлагатай

Гүйцэтгэх үүрэг:

- Постер, богино хэмжээний видео контент хийнэ.

11315735

nli.gov.mn info@legalinstitute.mn

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Ажлын байранд тавигдах ерөнхий шалгуур:

- Эрх зүйч эсвэл социологич мэргэжилтэй;
- Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- 1-ээс доошгүй жил судалгаа хийсэн туршлагатай;
- Англи хэл болон бусад хэлээр ахисан түвшний мэдлэгтэй бол давуу талтай.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Дипломын хуулбар;
- Төрийн албан хаагчийн анкет;
- 3х4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Хувь хүний намтар;
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.

Гүйцэтгэх үүрэг:

Хууль зүйн болон нийгмийн ухааны тодорхой салбараар ахисан түвшний хавсарга болон суурь судалгааг шинжлэх ухааны арга зүйн дагуу хийж гүйцэтгэх, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, сургалт, семинар зохион байгуулах.

Бүртгэл: Сонирхсон этгээд бүрдүүлсэн материалаа info@legalinstitute.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Утас: 11-315735

nli.gov.mnМЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
МЭРГЭЖИЛТЭНХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Ажлын байранд тавигдах шаардлага:

- Боловсрол: Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- Мэргэжил: Мэдээлэл технологийн мэргэжилтэн;
- Ур чадвар: Багаар ажиллах чадвартай, хариуцлагатай.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Дипломын хуулбар;
- Төрийн албан хаагчийн анкет;
- 3х4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Хувь хүний намтар;
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.

11315735

nli.gov.mn info@legalinstitute.mn